

**ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН ЁС ЗҮЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОН ХАМТ
ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХУУЛЬ, МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН
ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААРХ ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2022 оны 06 дугаар
сарын 08-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч: Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Ж.Мөнхбат, Ё.Баатарбилэг, Б.Бат-Эрдэнэ, Б.Баярсайхан нараас 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо 2022 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен төрийн албаны үйл ажиллагаанд улс төржих, намчирхах, ялгаварлах байдал гарч байгааг арилгах зохицуулалтын талаар, Б.Баярсайхан төрийн албан хаагчдын дунд удирдах албан тушаалтны зүгээс хууль бус шийдвэр гаргахад нөлөөлөх дарамт гардаг байдлыг хянах, хариуцлага тооцох талаар, Б.Баттөмөр Ёс зүйн зөвлөл, Ёс зүйн хорооны үйл ажиллагаа, гишүүний тоо бусад чиг үүргийн талаар, Х.Баделхан төрийн албанд бодит байдал дээр гардаг доголдол, зөрчлийг Ёс зүйн зөвлөл болон хороогоор хэлэлцүүлэх, гаргасан шийдвэрийн хэрэгжилтийн үр дүнг тооцох зохицуулалтын талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен төрийн албан хаагчийн ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх цаг үеийн чухал шаардлага байгаа талаар, Б.Баярсайхан төрийн албаны ёс зүйн хэм хэмжээг сайжруулах, Ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, хариуцлагыг нэмэгдүүлэхэд энэ хуулийн төсөл чухал нөлөөтэй бөгөөд нийгмийн захиалга үүссэн, цаг үеэ олсон талаар, Б.Баттөмөр төрийн албанд мөрдөх стандарт, баримтлах ёс зүйн хариуцлага, ёс зүйн код, мэдлэг чадварын стандарт, шатлан дэвших хэм хэмжээг нарийвчлан тогтоох, биеэ зөв авч явах, хувцаслалт, харилцаа хандлагын асуудлыг тодорхой тусгах талаар, Б.Бат-Эрдэнэ төрийн албаны ёс зүй, сахилга, хариуцлагыг чангатгах нь нийгмийн бүх салбарт зөв төлөвшил тогтоох, нийтийн эрх ашгийн үүднээс сахилга хариуцлагыг сайжруулахад чухал үр дүнтэй талаар, Ж.Мөнхбат хариуцлагатай, сахилгатай, ёс зүйтэй нийгэм төлөвшихөд ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх зохицуулалтыг нарийвчлан тусгах нь чухал алхам болох талаар тус тус санал хэлсэн болно.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд 100 хувийн саналаар дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.


Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан

сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Захиргааны ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хувьд хэлэлцэх эсэх талаарх Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ЁС ЗҮЙ, САХИЛГА ХАРИУЦЛАГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА**



Б.БАТ-ЭРДЭНЭ